

2

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 2 дугаар сар 12

№ 01

Дархан Уул аймаг

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн хурлын тооллогын комиссийн №01, №02, №03 тоот шийдвэрүүдийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2014 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж, хангалттай гэж үзсүгэй.
2. Компаний аудитын хорооны 2014 оны ажлын тайлан, дүгнэлтийг хэлэлцэж, хангалттай гэж үзсүгэй.
3. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалтыг хэвээр нь ажиллуулах, ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүдийг нэгдүгээр хавсралтаар, ТУЗ-ийн хороодын дарга, гишүүдийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
4. Компаний санхүүгийн үйл ажиллагааны чадвараас хамаарч ноогдол ашиг хуваарилах боломжгүй гэж үзсүгэй.
5. Дархан нэхий ХК-ийн 2014 оны аудитын хорооны шалгалтын дүнгээр илэрсэн эрх зүйн зөрчилтэй баримт бичгийг засаж, залруулан өөрчилсөн Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм, “Дархан нэхий” ХК-ийн охин, салбар компанийн компаниудын үйл ажиллагааны ерөнхий журам, Дархан нэхий ХК-ийн захирлуудын зөвлөлийн ажлын журмыг тус тус хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Р. СҮМБЭНХҮҮ



“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИ

Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн район
Шуудангийн хайрцаг 901, Утас: (976) 1372 28499
Факс: (976) 1372 23149, E-mail: nekhii@yahoo.com
Website: www.nekhii.mn

ДАРХАН НЭХИЙ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР

2015.02.12

№ 01

Дархан –Уул аймаг

"Дархан Нэхий" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдсон тооллогын комисс хуралд оролцогчдын бүртгэлийг үндэслэн дараах шийдвэрийг гаргаж хурал/хурлын дарга/-д хүргүүлсүгэй/Ирцийн бүртгэлийг хавсаргав. Хавсралт 1/. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд "Дархан Нэхий" ХК-ийн нийт хувьцааны 906498 ширхэг буюу 82 %-ийг эзэмшигчид оролцож буй тул хурлын ирцийг "хангалттай" гэж үзэх.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА М.Оюунчимэг./





“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИ

Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн район
Шуудангийн хайрцаг 901, Утас: (976) 1372 28499
Факс: (976) 1372 23149, E-mail: nekhii@yahoo.com
Website: www.nekhii.mn

ДАРХАН НЭХИЙ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР

2015.02.12

№ 02

Дархан –Уул аймаг

"Дархан Нэхий" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисс хуралд оролцогчдын дунд явуулсан санал хураалтын үр дүнг үндэслэн дараах шийдвэрийг боловсруулан хурал/хурлын дарга/-д хүргүүлсүгэй. Үүнд:

1. "Дархан Нэхий" ХК-ийн ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүдийг сонгох /батлагдсан компанийн дүрмээр нийт 9 хүн байна/ нээлттэй санал хураалтын дүнгээр:
 - 1.1 Эрдэнэдалайн Батсайхан- Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
 - 1.2 Равжаагийн Сүмбэнхүү - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
 - 1.3 Банзрагчийн Түвшин - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
 - 1.4 Далхжавын Батжаргал - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
 - 1.5 Хумбагайн Золжаргал - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
 - 1.6 Баасангийн Гэрэлмаа - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар тус тус **хараат гишүүнээр**;
 - 1.7 Жадамбагийн Баярсайхан - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
 - 1.8 Шаравжамцын Мөнгөндуулга - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар;
 - 1.9 Лувсандоржийн Оюунгэрэл - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар тус тус **хараат бус гишүүнээр** сонгох.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА/М.Оюунчимэг./





“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИ

Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн район
Шуудангийн хайрцаг 901, Утас: (976) 1372 28499
Факс: (976) 1372 23149, E-mail: nekhii@yahoo.com
Website: www.nekhii.mn

ДАРХАН НЭХИЙ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР

2015.02.12

№ 03

Дархан –Уул аймаг

"Дархан Нэхий" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисс хуралд оролцогчдын саналын хуудсыг тоолж үр дүнг үндэслэн дараах шийдвэрийг боловсруулан хурал/хурлын дарга/-д хүргүүлсүгэй/Саналын хуудсуудыг хавсаргав/. Үүнд:

1. "Дархан Нэхий" ХК-ийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцээд хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 81.99 хувийн саналаар "Дархан Нэхий" ХК-ийн 2014 оны үйл ажиллагааг "хангалттай" гэж дүгнэх;
2. Аудитийн хорооны 2014 оны ажлын тайланг дүгнэн хэлэлцээд, 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 81.99 хувийн саналаар "хангалттай" гэж дүгнэв.
3. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, ТУЗ-ийн төсвийг хэлэлцээд хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар батлав.
4. Ноогдол ашиг хуваарилах тухай хэлэлцээд, хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 81.99 %-ийн саналаар ноогдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэв.
5. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм, "Дархан Нэхий" ХК-ийн охин, салбар компаниудын үйл ажиллагааны ерөнхий журам, "Дархан Нэхий" ХК-ийн захирлуудын зөвлөлийн ажлын журмыг хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82 хувийн саналаар батлав.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА М.Оюунчимэг./

